

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-11</i>

- 
- 1. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** *3-11*

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55,6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн;

Чөлөөтэй: Д.Өнөрболор, М.Оюунчимэг, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Доржханд.

**Нэг. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын референт Д.Нямдэлгэр, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, Санхүүгийн зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Х.Мөнхжаргал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Б.Гэрэлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Ж.Ганбаатар, Ч.Ундрам, Ж.Бат-Эрдэнэ, Н.Ганибал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр, Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Б.Гэрэлээ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

**“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 34 минут үргэлжилж, 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 10 цаг 53 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 10 цаг 19 минут

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Цэрэнпунцаг:** Эрхэм гишүүдийн  
байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ  
өглөөний амгаланг айлтгая.

Өнөөдөр Байнгын хорооны  
хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн  
нэрсийг танилцуулъя. Наянтайн Ганибал  
гишүүн орон нутагт ажиллаж байна.  
Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн  
гадаадад томилолттой. Ингээд бусад  
гишүүд хүрэлцэн ирж, өнөөдрийн  
Байнгын хорооны хуралдааны ирц 55,6  
хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн  
байнгын хорооны 2024 оны 1 дүгээр  
сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг  
мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар  
хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. 1  
асуудал байна.

““Эрдэнэс Тавантолгой”  
хувьцаат компанийн хувьцааны талаар  
авах зарим арга хэмжээний тухай”  
Монгол Улсын Их Хурлын тогтоолын  
төсөл /Засгийн газар 2023 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр нэн яаралтайгаар  
өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ энэ  
хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр  
саналтай гишүүд байна уу. Алга байна.  
Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Хэлэлцэх асуудал. Нэг.** ““Эрдэнэс  
Тавантолгой” хувьцаат компанийн  
хувьцааны талаар авах зарим арга  
хэмжээний тухай” Улсын Их Хурлын

**тогтоолын төслийн эцсийн  
хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Чуулганы нэгдсэн хуралдааны  
анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг  
авсан саналын томъёоллыг тогтоолын  
төсөлд нэмж тусгасан эцсийн  
хувилбарын төслийг та бүхэнд тараасан.

Төслийг Байнгын хорооны болон  
чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн  
хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын  
хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын  
гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын  
байнгын хорооны дарга, ажлын хэсгийн  
ахлагч Б.Баттөмөр танилцуулна.  
Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

**Б.Баттөмөр:** ““Эрдэнэс  
Тавантолгой” хувьцаат компанийн  
хувьцааны талаар авах зарим арга  
хэмжээний тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төслийг бэлдээд Улсын Их  
Хурлын чуулганаар хэлэлцүүлсэн. Энэ  
дээр гол саналууд 1 дүгээр санал 2, 3, 4, 5  
гээд үндсэндээ бол дэмжигдсэн явж  
байгаа. 6 дугаар санал дээр бас нэг  
өөрчлөлтүүдийг хийе гэсэн санал гараад,  
тэгээд өчигдрийн хуралдаанаас тийм  
шийдвэр гарсан л даа. Тэгэхээр энэ 6  
дугаар саналыг яах вэ Ганбат аа, танайх  
Наранцогт хаачсан юм.

Энэ дээр бол төслийн төслийн 6  
дугаар заалтыг хасах гэж байгаа юм.  
Тэгэхээр энэ заалтыг хасах уу, эсвэл  
Засгийн газрын ирүүлсэн саналыг хэвээр  
нь явуулчих уу гэсэн ийм л юм байгаа.  
Тэгэхээр миний санал бол тогтоолын 2  
дугаар заалтыг хасах гэдэг энэ санал нь  
тэгээд явдгаараа явчихвал яасан юм л  
гэсэн санал байгаа шүү дээ тийм ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн  
танилцуулгаас асуух асуулттай гишүүд  
байна уу. Алга байна. Энэ 2 дугаар хэсэг  
нь ийм байгаа шүү. 1 л заалт байгаа юм.  
Зарчмын зөрүүтэй саналуудын 6 дахь  
санал байна уу. Хамгийн сүүлийн санал  
байгаа. Энэ нь Засгийн газраас ирүүлсэн  
төсөл дээр 2010 оны Их Хурлын 39

дүгээр тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгоё гэсэн юм оруулж ирснийг нь ажлын хэсгээс гаргасан саналаар бол энийг нь буцаад хасъя гэсэн юм. Тэгэхээр энэ хүчин төгөлдөр үлдэнэ л гэсэн үг. Тэгэхээр бид нэгэнт энэ Баялгийн сангийн хууль ярьж байна. Энэ богинохон хугацаанд бол энэ 2010 онд гаргасан Их Хурлын тогтоолоо бол аваад үлдчихье гэдэг томъёололтой чуулган дээр санал хураалгаад энийгээ ингээд тэр чигээр нь явуулчихъя гэсэн ийм л асуудал. Болж байна уу Баттөмөр дарга аа. Ажлын хэсгийн 5 номер Ганбат дарга. 1 номер Түвшинжаргал дарга хариулчих.

**Э.Түвшинжаргал:** Байнгын хорооны гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээр 2 дугаар заалт нь энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол болоод 2012 оны 18 дугаар тогтоолуудыг бол хүчингүй болгохоор оруулж ирсэн. Энэ тогтоолыг Их Хурлын ажлын хэсэг бол хасахгүй хэвээр нь үлдээе гэсэн ийм зарчмын санал гаргасан байгаа. Дэмжигдсэн явж байгаа. Үүний цаана ямар үр дагавар гарах вэ гэхээр 39 дүгээр тогтоол дээр юу үлдэж байгаа гэхээр Аж ахуйн нэгжүүд 10 хүртэлх хувь, Хөрөнгийн биржээр дотоод, гадаадын хөрөнгийн биржээр 20 хувь, иргэдэд оногдуулах хувь бас 20 гээд тэр заалтууд бүгд л хүчинтэй үлдчихэж байгаа юм. Тэгэхээр одоо энэ тогтоол батлагдсанаар иргэдэд бол 27 хувь очно. Тэгэхээр энэ заалтууд үлдэхээр нийт 57,2 хувь орчим нь ямар нэгэн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа арилжаалагдах эрх нь бол нээлттэй үлдчих гээд байгаа юм. Тэгэхээр Засгийн газрын ажлын хэсэг Засгийн газраас барихдаа 66/34 гэдэг хувийг барьж, тогтоолын төслийг оруулж ирсэн ийм концепт жосоохон зөрчигдөж байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ганбаатар гишүүн асуулт асууна. Тэрний өмнө нэг тайлбар хэлчихэд сая Түвшинжаргал

дарга сая тайлбарлалаа. Энэ 20 хувь хүртэлх эхний ээлжид тэгсэн байгаа шүү дээ. 2010 оны Их Хурлын тогтоол дээр. Одоо тэгэхээр бид нар 1 сая 200 мянган хүүхдэд олгоё гэж байгаа чинь бол эхний ээлж нь гэсэн 2 дахь ээлж нь бол таарч байгаа байхгүй юу. Тэгэхээр бол энэтэй нэг их зөрчилдөөд байх юм алга байна гэж үзэж байгаа учраас энэ Их Хурлын 2010 оны тогтоол ингээд байж байхад бол нэг их зөрчилдөөд сүйд болчих юм алга байна гэж бас манай хуульчид, Байнгын хорооныхон, ажлын хэсгийнхэн ингэж бас шийдэлд хүрсэн шүү. Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Ж.Ганбаатар:** Ер нь яах вэ, хувьцаа өгөх нь зөв л дөө. Хувьцаа бол өгөх нь зөв. Тэгэхдээ яг иргэдийнхээ хувьцааг ирээдүйд үнэ цэнтэй байлгах гэж байгаа бол энэ компанийг эхлээд хөл дээр нь босгох хэрэгтэй шүү дээ. Тэгээд л нэг хэдхэн хүнээ хатгаасаар юм уу, эс үгүй бол сөрөг хүчний тавьж байгаа тайлбараар ч юм уу ингээд. Энэ бол өөрөө ер нь бид нарын нэг мөнгө харахаараа л зүгээр л энд нэг мөнгө байна. Энийг ингээд хуваагаад хэрэглэхийг гэдэг ийм байдлаар. Тэгээд энэ компани өөрөө уг нь бол Ганбат өөрөө дуугармаар юм. Дуугарч байгаа байлгүй дээ. Өөрсдөө өчнөөн өр ширтэй. Яах вэ, Ганбат очоод энэ өр ширийг нь багасгаж л байгаа л даа. Тэгээд энэ төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлээд, ядаж нүүрсээ хагас боловсруулдаг болох хэрэгтэй байхгүй юу. Хагас боловсруулдаг. Хувийн компаниуд чадаад байхад төрийн компани энийгээ хурдан хийх ёстой. Үгүй ээ, тэгээд энэ иргэдийн хувьцааг үнэ цэнтэй, энэ компани өөрөө дэлхийд өрсөлдөх, ядаж нэг анхныхаа алхмыг хийх ёстой шүү дээ. Тэгээд хувьцааг нь өгөх нь зөв. Тэгэхдээ ирээдүйд энэ компани чинь өөрөө үнэ цэнтэй болох тусам энэ хувьцааны үнэ өртөг чинь нэмэгдэнэ. Хэрвээ энэ олж байгаа ашигийг нь ингээд л хуваагаад авчих юм бол ирээдүйд иргэдийн хувьцаа гэж уучлаарай Байнгын хорооны дарга маш сайн мэдэж байгаа хувьцааны үнэ

цэнийг. Тэгэхээр бид бол энэ ямар хамаатай юм, иргэдэд өгөх ёстой, энэ компанийн хувь заяа ямар хамаатай юм гэдэг байдлаар хандвал иргэдийнхээ хувьцааг л хорлож байгаа. Ирээдүйг нь л хорлож байгаа. Зүгээр өнөөдөр яах вэ хүмүүст сайхан сонсогдох л байх. Тэгэхээр энийг аль аль талыг нь анхаарах хэрэгтэй. Тэгэхдээ би бол 2023 онд өгөх нь зөв байна. Энийг бол өгөөд хуваарилаад өгөх нь зөв байгаа. Гэхдээ тэгээд ахиад нөгөө Засгаас орж ирснийг нь битгий өөрчлөөч ээ л гэж байгаа юм. Тэр сэргээгээд явна гэхээр ахиад л олон оныхныг өгөх хэрэгтэй болно гээд сая тэр 1 номерын дарга тайлбарлалаа л даа. Тэрийг би бол бас зөв, тэрийг сонсооч ээ л гэж хэлж байгаа юм Байнгын хороон даргад. Сонсооч ээ бас үндэслэлтэй шүү. Тэгээд Наранцогт нь хааччихсан юм. Яагаад Ганбат дуугарахгүй байгаа юм. Үгүй ээ, тэгээд энэ чинь нөгөө компанийнхаа хувь заяа энэ чинь одоо нэг жоохон ингээд нэг юм хиймээр байна шүү дээ. Юм хийгээд бүтээгээд, наад нэг компани өнөөдөр нэг чүү чаа хөл дээрээ нэг зөв тогтох гээд зөв чиглэлд явж байхад нь улам цааш нь дэмжээд, боломж олгоод түлхмээр байгаа байхгүй юу. Гэтэл ингээд зулгаагаад татаад байдаг. Тэгэхээр энийг бол Байнгын хороо, ялангуяа мэргэжлийн Байнгын хороо энэ дээр нэг тийм зөв байр суурьтай байгаач гэдгийг салбарын сайдын хувьд бол хүсэж байгаа юм. Манай асуудал бол биш л дээ. Гэхдээ би бас бодлого боловсруулж байгаа сайдын хувьд бол энийг бол хэлэхгүй байж үнэхээр чадсангүй. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хариулъя. Хариулахын өмнө би бас Ганбаатар сайд энэ салбарт байгаа энэ том компани төрийн өмчтэй өнөөдрийн байдлаар бол ашиг орлого сайтай ажиллаж байгаа энэ компанийнхаа талаар сэтгэл санаа тавьж ярьж байгаа асуудал бол бас зөв зүйтэй. Бид нар энийг Байнгын хороо дээрээ бас гишүүд маань тодорхой

нэгдсэн ойлголт байр суурьтай байж, компани нь цаашидаа яаж ажиллах юм, ямар хөрөнгө оруулалт хийх юм, яаж үнэ цэнтэй байлгах юм, хувьцаа эзэмшигчдийнхээ энэ хөрөнгийг яаж үнэ цэнд оруулах юм бэ гэдэг ирээдүйд яаж ажиллах юм гэдэг энэ бодлого, энэ бизнес төлөвлөгөө эд нар дээр бол тодорхой сайн төлөвлөгөө гаргаж ажиллах ёстой. Энэ бол компанийн өөрийнх нь ТУЗ, тэгээд хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаар оруулаад шийдэх асуудал. Ер нь бол өнөөдрийн энэ Байнгын хорооны тогтоол гарч байгаа. Энэ тогтоолоор шийдэж байгаа гол асуудал бол энэ 2012 оны 4 сарын 11-ээс хойш төрсөн 1 сая 200 мянган Монгол Улсын иргэн өнөөдөр энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа эзэмшигч болгож байгаа. Энд хоцорчихсон байсан энэ асуудлыг гол нь шийдэж байгаа. Дээрээс нь энэ тогтоолоор бол энэ хувьцаа бол энгийн хувьцаа юм гээд хувьцаагаа бас нэр томъёог нь тодорхойлж, хувьцаагаа бас тодорхой болгож өгч байгаа ийм ач холбогдолтой тогтоол. Тэгэхээр бол цаашидаа сая Ганбаатар сайдын хэлсэн энэ анхааруулгыг компани анхааралдаа авч ажиллах ёстой. Ер нь хамгийн гол нь үнэхээр бид нар Монголын ард түмэн бүгдээрээ хувьцаа эзэмшиж байгаа, эзэн нь болсон энэ компани нь цаашидаа үнэ цэнтэй, олон жил удаан хугацаанд үр ашигтай ажиллах, удаан хугацаанд дивидентээ хувьцаанд тарааж байх, цаашидаа энэ компанийн үнэ цэн улам нэмэгдэж байх ийм л стратеги бодлоготой ажиллах ёстой гэж хэлж байгаагаа бол дэмжиж байна. Ингээд Баттөмөр гишүүн хариулъя. Ганбаатар сайд тодруулж асууя.

**Ж.Ганбаатар:** Би нөгөө Байнгын хорооныхоо гишүүнийхээ хувьд үг хэлж байгаа юм. Тэгээд мэдээж иргэд бүгдээрээ хувьцаа эзэмших нь зөв л дөө. Энэ дээр бол 100 хувийн саналтай байна. Хувьцаа эзэмших нь зөв. Харин зүгээр түрүүн нөгөө хариуллаа шүү дээ. Тэр өмнөх тогтоолыг сэргээчихээр тэгээд л бүх л олж байгаа ашиг орлогоо бүгдийг

нь тэгээд л хувьцааны ноогдол ашиг гэдгээр юм уу тараагаад, ирээдүйн нөгөө төсөл хөтөлбөрүүд нь бүгдээрээ зогсчих вий л гэдэг л ийм л санаа. Тэр тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хохирч байгаа. Энийг л ойлгоосой л гэж байгаа юм. Тэгээд эд нар чинь тэгээд тэрийг Их Хурал ингээд өгчихсөн, шийдвэр гаргачихсан Байнгын хороо ингээд шийдвэр гаргачихсан биелүүлнэ л гээд л. Ер нь бол ирээдүйд нь санаа зовж байгаа хүмүүс хэр их олон байгаа бол доо. Өнөөдрийнхөө ажлыг л яаж байгаа бол ирээдүйд нь санаа зовоосой зовоорой.

**Ц.Цэрэнпунцаг:** Ундрам гишүүн асуулт асууя.

**Ч.Ундрам:** Яг одоо бидний энэ шийдэх гэж байгаа асуудал 2010 оны 7 сарын 7-нд гарсан 39 дүгээр тогтоол байгаа шүү дээ. Нөгөөдөх нь 2012 оны 2 сарын 16-нд гарсан 18 дугаар тогтоол.

39 дүгээр тогтоол дээр иргэдэд 10 хувь, аж ахуйн нэгжүүдэд 10, гадаадын хөрөнгийн бирж дээр 30 хүртэлх хувь гэгчихсэн байгаа.

18 дугаар тогтоол дээр болохоор иргэдийнхээ 10 хувийг 20 болгоод, аж ахуйн нэгжүүдийн 10 хувийг хэвээр нь үлдээгээд, гадаадын хөрөнгийн биржийг 30-20 хувь болгоод бууруулчихсан. Энэ 2-ыг хүчингүй болгоё гэсэн ийм санал Засгийн газраас бол орж ирсэн юм байна. Тэгэхээр үүний цаана би юу гэж харж байна вэ гэхээр иргэдэд нь өгөх хувь нь одоо бид нар нэмэлт 2012 оноос хойш төрсөн хүүхдүүдэд өгчихөөр иргэдийн хувь өсчхөж байна. Тэгэхээр энэ нь бол яг эндээ таарахгүй байна гэсэн нэг асуудал. 2 дугаарт, аж ахуйн нэгжүүдэд Монголын яг мэргэжлийн салбарын аж ахуйн нэгжүүдэд 10 хувийг ер нь өгөхөө больё гэдэг агуулга цаана нь явж байгаа юм болов уу гэж бодож байна.

3 дугаар агуулга нь гадаадын хөрөнгийн бирж дээр арилжаалах асуудлыг дараа нь тусдаа Улсын Их

Хурал тухайн үедээ шийдэх юм уу, үгүй юу. Одоохондоо больё гэдэг ийм цаад утга санаа явж байгаа юм байна гэсэн ийм бодол бол надаа төрж байна.

Тэгэхээр бид нар өнөөдөр шийдвэр гаргахдаа цаашид бид нар энэ хөрөнгийн бирж дээр гадаадын хөрөнгийн бирж дээр энэ компанийн хувьцааг гаргах юм уу, үгүй юу. Тэгээд энэ аж ахуйн нэгжүүдийн 10 хувийг бол тухайн үед оруулахдаа аж ахуйн нэгж хэрвээ тодорхой хувьцаа эзэмшдэг болчих юм бол хяналт бол бүр мэргэжлийн болоод ирнэ. Өнөөдөр зүгээр хувь иргэн очоод энд нэг их сүртэй “Эрдэнэс Тавантолгой” дээр хяналт тавиад л, санхүү тайлантай нь танилцаад л, энэ нь болж байна, тэгэх ёстой гээд байх хүч байхгүй шүү дээ. Мэдлэг, туршилага ч гэсэн дутна. Аж ахуйн нэгжүүд 10 хувь авчих юм бол бүр мэргэжлийн хараа хяналтууд орж ирнэ гэдэг утгаар энэ 10 хувийг оруулсан байсан байх гэж би бодож байгаа. Тэгэхээр яг энэ алсын харааг яг нөгөө бодлогын яам Ганбаатар сайд яг юу гэж бодож байгаа юм бэ гэдэг л бид нар шийдвэр гаргахад маш чухал байх л гэж. Миний байр суурь юм байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Хэн хариулах ёстой юм бол. Ажлын хэсэг хариулах уу. Ганбаатар сайд хариулах юм уу энэ чинь. Ер нь юу шүү дээ түрүүн би бас хэлсэн шүү дээ. Энэ Их Хурлын тогтоол гарч байгаа. Ер нь 2010 онд гарсан Их Хурлын тогтоолыг бид нар ингээд хүчин төгөлдөр үйлчилгээтэй орхичиход бол өнөөдөр нэг их айхтар зөрчилдөөд байгаа юм байхгүй юм байна гээд бид нар олон талаас нь ярьсан. Зүгээр хамгийн гол нь өнөөдөр энэ бүх асуудлууд бол Баялгийн сангийн хууль Засгийн газраас өргөн барих гэж байгаа. Тэгээд энэ Баялгийн сангийн хууль бол удахгүй Улсын Их Хурлаар хэлэлцэгдэх юм байна гэж бид нар ойлгож байгаа юм. Тэгээд үүгээрээ энэ асуудлууд бол нэг мөр шийдэгдэх юм байна. Тэгэхээр энэ Баялгийн сангийн хууль гарахтай холбогдуулаад, авч

хэрэгжүүлж байгаа бэлтгэл ажилтай холбогдуулаад энэ Их Хурлын тогтоол гарснаар Баялгийн сангийн хуулиар бас шийдэхэд хэцүү 1 сая 200 мянган хүүхдийн шинэ хувьцаа эзэмшигчдийн асуудлыг хамгийн гол нь шийдээд, дээрээс нь бас нэг алхам хийгээд, энэ хувьцаагаа бид нар энгийн хувьцаа юм шүү гэдэг нь бас тодорхой нэр томъёог нь тодорхой болгож өгөөд гаргаж байгаа тогтоол байгаа юм. Тэгэхээр түрүүний тэр Түвшинжаргал даргын яриад байгаа хуулийн хувьд бол бас зөрчил үүсээж магадгүй асуудал нь бол тэр 20 хувь хүртэл олгочихсон байна. Энэ хязгаарлалт чинь байгаад байна шүү гээд байгаа юм. Энэ бол эхний ээлжид гэгчихсэн байгаа шүү тэр тогтоол дээр. Тэгэхээр бид нар олон талаас нь ярьсан. Эхний ээлжид гэгчихсэн байж байгаа бид нарын 1 сая 200-г нэмээд олгож байгаа бол тэр 20-с дээш гараад явж байгаа бол 2 дахь ээлж л байхгүй юу. Дахиад 3 дахь, 4 дэх ээлж гээд мэдээж тогтоол бол гараад явахгүй байх. Яагаад гэвэл Баялгийн сангийн хууль гарах гэж байгаа учраас энэ асуудал нэгмөсөн шийдэгдчихнэ гэж харж байгаа юм.

Тийм учраас бид нар Баялгийн сангийн хуулиа хийхэд дахиад энэ дээр бид нар бас ялгаварлаад, тэр 1 сая 200 мянган хүүхдийг дахиад Монголын хүн амын тодорхой хэсгийн хувьцаа эзэмших асуудлыг нь хуулиар шийдэх асуудал гарч ирээд энэ нь бас хууль зүйн хувьд бас асуудал үүсгээд байж магадгүй гэдэг асуудлуудыг урьдчилан шийдэж явж байгаа учраас эрх зүйн дүгнэлт ч гэсэн тэр чиглэлд гарсан. Өчигдөр эрх зүйн дүгнэлтийг Мягмар дарга бид нарт тодорхой танилцуулж, энэ дээр асуулт, хариулт Байнгын хороо дээр явагдаад гишүүд асуугаад энэ дээр нэлээн тодруулсан шүү дээ. Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Би бол “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 хувьцаанд ноогдох ноогдол ашигийг өг гэж байгаа шүү. Өг. Зүгээр нүдээ аниад өгчихье

хэдүүлээ. Яагаад. Ер нь төрийн шийдвэрээр нэлээн их хэмжээний мөнгө наад “Эрдэнэс Тавантолгой”-н чинь мөнгийг ашиглачихсан шүү дээ. Нэг хэсгийг нь төмөр зам руу аваад явчихсан. Бүр нэг жишээ татахад Багануурын уурхайд та нар хэдийг өглөө. 1 их наяд гаран болчихсон. Тэр хэмжээний мөнгийг өгчихсөн шүү дээ. Тэгээд наад компаниуд чинь өөрөө дампуурах гээд байна шүү дээ. Одоо тэгээд хэрвээ иргэдийн хэдэн төгрөг өгчихвөл тэгээд энэ компани дампуурах гээд байна энэ тэр гээд ингээд уйлан дуулан суугаад байх юм. Наад төрийн албыг чинь хашиж байгаагүй биш, хашиж байсан шүү дээ. Ганбат орж ирээд энэ чинь дотоод асуудлуудыг нь сайжруулж байгаа байхгүй юу. Яг үндсэндээ бол энэ компанийг дампуурах ажлыг хэн хийсэн юм. Төрийн байгууллагууд өөрсдөө хийчхээж байгаа шүү дээ. Засгийн газар өөрсдөө хийчхээж байгаа шүү дээ. Тэгээд энэ компани тэгвэл дампуураг. Харъя хэдүүлээ. Нэг талаас нь төр нь хумсалж аваад ийшээ тийшээ ингэж хамаагүй замбараагүй зарж аваад эдний компанийн мөнгийг. Нөгөө талаас нь үлдэгдлийг нь аваачаад хэдүүлээ ноогдол ашиг болгоод өгчихье л дөө. Тэгээд дампуураг. Тэгээд тэрийг дампуурсных нь дараа тэгвэл хэн нь зөв байсан юм. Иргэддээ ноогдол ашиг олгох нь буруу байсан юм уу, зөв байсан юм уу. Эсвэл одоо тэр цаанаас нь төрийн мөнгө аваад тэр Багануурт өгсөн нь зөв байсан юм уу, буруу байсан юм уу үзье л даа хэдүүлээ. Ил тод болгоё л доо. Тэгж байгаад асуудлаа шийдье л дээ. Энэ дээрээ тулж очиж байж хэдүүлээ асуудлуудыг шийдэхгүй, дарж хэвтсээр байгаад нэг мэдэхэд бүх асуудлуудыг нь дэлгээд харахад л нөгөө компани чинь өөрөө дампуурчихсан сууж байна шүү дээ. Дампуурчих гээд сууж байна шүү дээ. Зөв шүү дээ. Одоо жишээ нь салбарын сайдын хэлдэг асуудлыг бол би нэг талдаа дэмжиж байгаа. Салбарын сайдын хувьд энэ чинь ингээж хэлэх ёстой. Яагаад гэхээр энэ компанийг дампууруулж болохгүй. Гэхдээ л тодорхой шийдвэрүүд гаргаад, танай

хэдэн төгрөгийг чинь авчихсан шүү дээ. Миний мэдэхийн миний байх үед бол жилийн 700 хэдэн сая долларын орлоготой ийм л компани байсан. Тухайн үед нь хэдхэн 100 мянган долларын юу ч билээ нэг тодорхой хэмжээний мөнгийг л бид нар чинь төмөр зам руу оруулчихъя гэж ярьж байсан шүү дээ. 100 сая долларыг л өгчих гэж гуйж байсан. Тэгж байж төмөр замаа хөдөлгөө гэсэн болохоос биш бүх мөнгийг нь шавхаж аваачаад төмөр зам руу хийчихье гэсэн схемийг би гаргаж ирээгүй шүү дээ тухайн үед. Бараг л энэ дотор байж байгаа хүмүүс мэдэж байгаа шүү дээ. Тэгэхээр би эхлээд өг гэж хэлнэ гэж байгаа юм. Өг. Тэгээд хэдүүлээ харъя л даа аль нь зөв байсан юм, аль нь буруу байсан юм. Тэнцвэрээ хадгалаад үзье.

Ер нь мэдээж энэ чинь компанийнхаа үйл ажиллагааг бодож байж, хэдэн төгрөг нь хаашаа гарах юм, хэд нь хөрөнгө оруулалтад оруулах юм, хэд нь цаашаагаа энэ компанийн ирээдүйг нь авч явах юм, хөл дээр нь босгох юм тэгснийхээ дараа уг нь зарчмын дагуу дараа дараагийнхаа мөнгийг ноогдол ашгаа олох ёстой шүү дээ. Тэгээд ингээд яриа сонсоод байсан чинь уучлаарай бас хэлэхгүй бол болохгүй зүйл гараад ирж байна шүү дээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Бат-Эрдэнэ гишүүн ерөнхийдөө санал хэллээ. Та хариулах уу. Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хариулъя.

**Б.Баттөмөр:** Сая тэр Ганбаатар сайдын хэлж байгаа зүйтэй л дээ. Ер нь нөгөө саалийн үнээгээ алаад идчихлээ гэдэг шиг ирээдүйд үр ашиг өгөх юмаа бас хамгаалъя гэдэг санаа бол зүйтэй. Тэгээд энэ тогтоолд ерөөсөө тэр хувьцааны ашиг өгнө, өгөхгүй гэсэн юм ерөөсөө байхгүй. Энэ бол Монголын 2012 оны 4 сарын 1-ээс хойш төрсөн 1 сая 5 мянган хүүхэд байгаа шүү дээ. Энэ хүүхдүүдэд л 1072 хувьцааг нь өгч байгаа шүү дээ. Одоо 18 хувь нь иргэдэд байгаа.

Тэгээд энэ хүүхдүүдэд ингээд өгөхөөр 27 хувь болох юм. Тэр ноогдол ашиг хуваах асуудал тэр Баялгийн сангийн хуулиараа ээлжит бус чуулган хийгээд шийдье гэж байгаа шүү дээ. Энэ бол зөвхөн хүүхдүүдийг хувьцааг нь эзэмшүүлж баялгийн эзэд болгож байгаа л гэсэн ийм юм явж байгаа. Ер нь бол баялгийн сангийн хууль батлах, тэгээд энэ ноогдол ашиг тараах үедээ тэр компанийн цаашидын ирээдүй тэр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх энэ чиглэлд бол тодорхой хэмжээний мөнгө зарцуулах нь зүйтэй. Ийм байгаа юм. Тэгээд өнөөдрийн хэлэлцэх асуудал энэ б дугаар заалтыг төслөөс хасах уу, хасахгүй юу гэсэн ганц асуудал байгаа. Тэгэхээр Цэрэнпунцаг дарга аа, энэ төслийн заалтыг төслөөс хасах гэдэг хэвээр нь ингээд үлдээгээд, 2010 онд гарсан тогтоол шүү дээ. 39 дүгээр тогтоол хэрэгжээгүй. Ингээд л явж байгаа. Тийм учраас энэ Байнгын хорооны зөвлөхүүдтэй ярьснаар бол энэ тогтоол байж байхад бол нэг их тийм цаашидын тэр үйл ажиллагаанд хор хохирол учрахгүй гэж ингэж ойлгож байгаа шүү дээ. Тийм учраас бол төслийнхөө энэ заалтаар ингээд явдагараа тэгээд явъя л гэж байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Сая Баттөмөр дарга бүр сайн тайлбарлалаа. Энэ тогтоолоор хөндөж байгаа асуудал ерөөсөө 2 тодорхой асуудал байгаа юм шүү. Бид нар тэр ашиг орлогыг ингэж хуваарил, тэгж хуваарил, тэдийг нь хөрөнгө оруулалт хий, тэдийг нь хувьцааны ашиг болгож тараа гэж бол эндээс өнөөдөр шийдвэр гарахгүй байгаа юм. Тэгэхээр өнөөдөр бол бүгдээрээ энэ асуудлаа шийдээд ер нь бол удахгүй бидэнд нэг ойлголт байгаа шүү дээ. Баялгийн сангийн хууль орж ирнэ гэж. Тэрүүгээр энэ 2010 оноос хойш бас хэдэн тогтоол байна. 6, 7 тогтоолоор гарсан хэчнээн удаа тогтоол гаргаад л Их Хурлаас шийдвэр гаргаад л компанийн ажилд дээрээс оролцоод л мөнгийг нь аваад явчихдаг байсан бол энийг нэгмөсөн 1 талд нь гаргаж шийдэж

байгаа асуудал бол тэр Баялгийн сангийн хууль гарснаар шийдэгдэх юм байна гэж ойлгоод бид нар ерөнхийдөө үүний бэлтгэл ажлыг хийж байгаа шүү. Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тогтоолын төслийг дэмжиж байна. Ер нь бид бүхэн иргэддээ тэр энгийн хувьцаа болгоод, энэ Баялгийн сангийн хуулиараа холбоод ер нь яагаад “Эрдэнэс Тавантолгой” дампуурах гээд байгаа юм бэ гэдгийг ер нь бүгдээрээ бас бодож үзэх ёстой л доо. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр нууцад оруулсан олон оффтейк гэрээнүүдийг санхүүжүүлснээс болоод, тэр төслүүд нь үр дүнтэй байхгүй байгаагаас болоод өнөөдөр энэ компани дампуурах гэж байгаа. Тэрнээс ямар иргэд тэндээс мөнгө авснаараа дампуурч байгаа эд биш шүү дээ. Иргэд харин хувьцаандаа жил болгон ноогдол ашгаа аваад эхлэх юм бол үнэхээр иргэдийн тэр хяналтад орж эхэлнэ. Өнөөдөр Монголын ард түмэн “Эрдэнэс Тавантолгой” дээр 1072 хувьцаа эзэмшдэг боловч хамгийн гол нь энэ компани өнөөдрийг хүртэл бүх нийтэд хаалттай байгаа юм. Тэгээд хаалттай байгаа тэр компанийг иргэд хянах ямар ч боломжгүй. Харин жил болгон олж байгаа орлого нь хувьцаандаа ноогдсон тэр ноогдол ашгаа аваад эхлэх юм бол тэр хяналтаа илүү тавиад эхэлнэ. Тэрнээс бол хэн ч мэдэгдэхгүй, хэн ч мэдээлэл өгөхгүйгээр хийгдсэн тэр олон төслүүдийн үр дүнгээс болоод энэ компанийн гол дампуурал гэдэг үгийг оруулж ирж яриад байгаа. Ер нь бол зүгээр бидэнд бол нөөц бололцоо нь бол их. “Эрдэнэс Тавантолгой” компани өнөөдөр 3, 4 ам нээгээд ажиллаж байгаа боловч цаана нь эргээд бид нарт олон нөөц байгаа. Энийгээ үр дүнтэй ажиллуулах боломж байгаа байхгүй юу. Яагаад иргэдэд мөнгө өгөх талаар хувьцааг энгийн болгоод иргэдийн хяналтыг оруулж ирэх гэхээр л энд ямар нэгэн ашиг орлого байхгүй болно, компанийн өр өчнөөн их байна гээд ингээд ярьдаг. Нууцаар гэрээ хийхдээ

болохоороо чимээгүйхэн хийгээд, цаашаа явдаг. Олон төсөл хэрэгжүүлсэн. Харамсалтай нь өнөөдөр тэндээсээ үр дүнгээ олоод, ашиг орлого олж байгаа тийм төсөл бол үнэхээр бас байхгүй байна.

Үгүй ээ, тэр манай нам, танай нам хамаагүй шүү дээ. Өнөөдрийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ямар ямар хүмүүс байсныг та хэд бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Энд улс төржилт хэрэггүй ээ. Бодит нөхцөл байдлыг яриад байна шүү дээ. Тэгэхээр энийгээ сайхан зас. Тэгээд засахын тулд энийгээ хийе гэж хэлж байна шүү дээ. Энэ дээр засаж байгаа асуудлаа болохоор одоо ярихаараа дампуурч байна гээд яриад байж болохгүй байхгүй юу. Үгүй ээ, та хэд түрүүний яриа дотроо олон асуудлуудыг ингэж яриад байна шүү дээ. Бүгдээрээ л иргэд мэдэж байна шүү дээ. Тэгэхээр харин энэ ноогдол ашиг жил болгон олгогдох ёстой юм. Сонгуулийн жил болохоор нэг тодорхой хэмжээнд багахан иргэдийн сэтгэл санааг тайвшруулах хэмжээний мөнгө өгөхөө боль. Жил болгон энэ орлого ашигийг нэмэгдүүлэх тал дээр хувьцааны ноогдол ашиг нь жилийн жилд өсөх ийм байдлаар л энэ ноогдол ашигийн асуудал явах ёстой. Тэгэхээр энэ дээр энгийн болгож энэ тогтоолын төслөө яаралтай батлуулах нь зөв л дөө. Баярлалаа. Асуулт байхгүй ээ Ганбаатар сайд аа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ганбаатар сайд хариулах юм уу. Асуултад хариулъя.

**Ж.Ганбаатар:** Ганибал гишүүн ээ, ер нь бол энэ ашигтай ажиллаж байгаа учраас өнөөдөр энэ асуудал яригдаж байгаа шүү дээ. 2010 оноос хойш яагаад энэ асуудал яригддаггүй байсан юм гэвэл юун ашиг битгий хэл. Тэнд чинь маш том асуудал байсан байхгүй юу. Тэгээд энийг чинь Засгийн газар өөрөө энэ Ганбат гэж хүнийг томилоод, энэ өнөөдрийн яригдах үндэслэлийг бий болголоо шүү дээ. Цаашаа улам их ашигтай ажиллах нөхцөлийг л тавьж өгөхийг бид хүсэж

байгаа юм. Өнөөдөр их наяд их наядаар ашигтай ажиллаж байна шүү дээ. Энийг хаана, хэн бий болгосон юм. Монгол Улсын Засгийн газар энийг бий болголоо шүү дээ. Хар л даа тэр саяын нүүрсний хэлэлцүүлгээр 400 доллар байхад нь 60-хан доллароор нүүрсээ зарж байсан. Өнөөдөр бид нар биржээр 180 доллароор нүүрсээ зарж байна шүү дээ. Тэгээд энэ ашигтай ажиллах нөхцөлийг бий болгосон. Цаашидаа улам ашигтай ажиллах нөхцөлийг бий болгох л ёстой. Түүнээс биш энд ингээд л тэгээд л янз янзын байдлаар саад тотгор битгий болчхоосой л гэж байгаа юм.

Түүнээс биш иргэдэд хувьцаа тараахаараа Наранцогт зүгээр яах вэ тэр үгний сонголтын алдаа л гаргасан юм шиг байна лээ. Тэрийг нэг их ингээд л аваад л тэр Наранцогтын үгээр дампуураад байх юм байхгүй. Энэ чинь ашигтай ажиллаж байна шүү дээ. Тэгэхдээ энэ компани өөрөө өртэй байна. Монгол улсад байхгүй бусад компанид энэ 3,5 их наядын өр байхгүй байх шүү. Маш их өртэй байгаа. Энэ өрийг харин таны хэлсэн тэр нөхцөлүүдийн үндсэн дээр тэр өр бий болсон. Энийг чинь харин сүүлийн нэг жил засаж байна. Монгол Улсын Засгийн газар, Их Хурал. Тэр үндэслэлийн хүрээнд өнөөдрийн энэ ашиг тараах нөхцөл чинь бий болсон байна шүү дээ. Энийг ирээдүйд улам их болгоно. Хэн нэгэн хүн, ямар нэгэн хүн ярьсан ч гэсэн бид энийг улам их болгоно. Өнөөдөр бид нар 30 хувиа нүүрсээ биржээр зарж байгаа бол 2024 онд 50 хувиа зарна. 2025 онд 80 хувиа, 2026 онд 100 хувь биржээр зарна нүүрсээ. Энэ тохиолдолд улам их ашиг тараах нөхцөл бүрдэнэ. Энийг баталгаатайгаар хэлье. Харин тэгээд өнөөдөр дампуурах гэж байгаа гэсэн энэ үгний сонголт Ганибал гишүүн ээ буруу байна шүү гэдгийг хэлье. Энэ бол Наранцогтын зүгээр яах вэ хариуцлагатай хэлээгүй байх, зүгээр үгийг нь гуйвуулсан байх гэж бодож байна. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг байхгүй. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалгаагүй, нээлттэй үлдээсэн саналаар санал хураалт явуулъя. Ингээд саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дэмжих юм шүү. Бид нар 2 дахин ажлаа хийчхэж байгаа юм л даа. Гишүүдийн 69,2 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Энд нэг найруулгын санал байгаа юм. Энийг зүгээр протоколд тэмдэглүүлэх юм шүү. Энэ яасан гэхээр Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээр “Эрдэнэс Монгол” нэгдэл гээд нэг ийм нэр томъёо яваад байгаа юм. Тэгээд өнөөдрийн хуулиар бол бид нар нэгдэл гэдэг ийм хуулийн этгээд ямар нэгэн хуулийн этгээд байхгүй. Хувьцаат компани гэж бий. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гэж байгаа. Тэгэхээр зэрэг энийг бид нар хууль, тогтоомжид нийцүүлээд энэ редакцын засвар хийх хэрэгтэй байгаа юм. “Эрдэнэс Монгол” нэгдлийн гэгчихсэн энийг бол “Эрдэнэс Монгол” ХХК, түүний гэж ингэж өөрчилж редакц хийх юм шүү. Тэгээд Наранцогт захирал алга байна шүү дээ. Уг нь өөрөөс нь асуугаад бас энэ протоколд үлдээчихье гэсэн. Та чинь энэ нэгдлийн захирал юм уу, “Эрдэнэс Монгол” нэгдлийн захирал юм уу “Эрдэнэс Монгол”-ынхноос байна уу. Танайх “Эрдэнэс Монгол” нэгдэл гэдэг ийм байгууллага юм уу. “Эрдэнэс Монгол” ХХК юм уу. Ажлын хэсгийн 3 номер хариулчих.

**Б.Гэрэлээ:** Өглөөний мэнд хүргэе. “Эрдэнэс Монгол” ХХК. Нэгдэл гэдэг нь компанийн тухай хуулиараа охин, хараат компаниудыг хэлж байгаа. Тэгэхээр “Эрдэнэс Монгол” нэгдэл болон түүний харьяа охин, хараат компани хуулийн этгээдүүдийг л хэлэх ёстой. Тэгэхээр нөгөө “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний гэдгээр л орно. Тэр нь бол зөв.

**Ц.Цэрэнпунцаг:** Бид нар өнөөдөр энд Их Хурлын тогтоол, хууль гаргаж байгаа. Тэгэхээр энэ хууль ёсных нь нэр томъёог нь ашиглах ёстой. Ингээд энийг ХХК гэж өөрчлөөрэй.

Ингээд санал хураалт явуулж дууслаа. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөлөө. Ингээд хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүд та бүхэндээ баярлалаа.

10.53 цаг

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ